



А.Амаржаргал
МУБИС-ийн Боловсрол судлалын төвийн ахлах мэргэжилтэн, магистр

ОЮУТНААР ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХ АСУУДАЛД

Abstract: Course evaluation in higher education is a way to ensure the quality of teaching and to reflect it for improving the course quality as well as using for teacher evaluation and salary compensation. This article is to compare course evaluation questionnaires in higher education organizations of some countries in order to review "Student satisfaction questionnaire" used in Mongolian National University of Education (MNUE). The student satisfaction questionnaire used in MNUE consists of eight items with two options of answers: satisfied or not-satisfied. The items are formulated to evaluate the content appropriateness, teacher's skill and teacher communication so on. However, the questions seem too general and choosing from only two answers can not give valid evaluation result. Meanwhile, the items in questionnaires used for comparison are designed to measure the course effectivity, teacher-student interaction and teachers' enthusiasm towards their teaching more detailed and accurately. A new course evaluation questionnaire is suggested from the comparison.

Key words: higher education, course evaluation, student satisfaction questionnaire, comparison from international perspectives

Дээд боловсролын чанарыг үнэлэх олон арга, шалгуур байдгаас их, дээд сургуулийн өөрийн оюутанд үзүүлж буй үйлчилгээнийхээ чанарыг үнэлэх нэг арга нь оюутнуудын хичээлд өгөх үнэлгээ буюу бидний хэлж заншсанаар оюутны сэтгэл ханамжийн судалгаа билээ.

Их, дээд сургууль зорилго, зорилтдоо нийцсэн боловсролын үйлчилгээ үзүүлж чадаж байгаа эсэх, хичээлийн агуулгыг системтэй, чанартай ойлгуулж байгаа эсэхээ байнга хянаж байх хэрэгтэй. Гадаадын улс орнуудад сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд оюутнуудаас асуулга анкет авч хичээл, багшийн үнэлгээнд хэрэглэдэг их, дээд сургууль цөөнгүй. Тэдгээр их сургуульд оюутан улирлын эцэст өөрийн судалсан

бүх хичээлд үнэлгээ өгөх тогтолцоо бүрдүүлсэн байдаг ба хичээлд үнэлгээ өгснөөр, хичээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх санал гаргах, багшийн ажлыг үнэлэх, багшийн цалингийн нэмэгдэл, шагнал тодорхойлоход чухал баримт болгон хэрэглэдэг.

Гэвч үнэлгээгээр гарсан дүн үнэн зөв, хичээлийг сайжруулах санал болохуйц байх нь чухал. Иймд асуулга шаардлагатай хүрээг хамарсан, оновчтой, ойлгомжтой байх, оюутан зөв, шударга үнэлгээ өгөх чадвартай байх, бодитой үнэлгээ хийдэг байх хэрэгтэй.

МУБИС-д оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ авч, багшийн ажлын үнэлгээнд тусгадаг. Энэхүү өгүүлээр уг үнэлгээний асуултуудад анализ хийж, оюутнаас авдаг хичээлийн үнэлгээг хэд хэдэн орны их сургуульд хэрэглэдэг хичээлийн үнэлгээ (course evaluation)-ний агуулга, асуултын жишээн дээр харьцуулалт хийж үзлээ.

МУБИС

МУБИС-д өнөөгийн байдлаар хичээлийн үнэлгээ хийх нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байна. Гурван жилд нэг удаа хийгддэг багш нарын аттестатчиллын үед багшийн талаарх оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ авч, багшийн ажлын үнэлгээнд тусгадаг.

Мөн сургалтын алба нь энэхүү асуулгаар багшийн ажлын үнэлгээ хийдэг боловч энэ нь тухайн улирал, жил бүрээр багшийн ажилд үнэлгээ өгөх, хичээлийн сайжруулах санал зөвлөгөө болон төдийлөн тусгагддаггүй.

МУБИС-д одоогийн байдлаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг дараах асуултуудаар авч байна.

1. Багшийн заадаг хичээл оюутны хэрэгцээ, сонирхолд нийцдэг эсэх
2. Багшийн харилцааны соёл, үлгэрлэл
3. Хичээлийн цаг ашиглалт
4. Явцын болон улирлын шалгалтыг төлөвлөсөн хугацаандаа чанартай авч бодитой үнэлдэг эсэх
5. Багшийн оюутанд тусалдаг байдал

6. Хичээлийг заах үр чадвар
7. Багш ёс зүйн зөрчил гаргадаг эсэх
8. Багшийн гардаг зөрчил болон сайн талыг чөлөөтэй бичих

Асуултад хангалттай, хангалтгүй гэсэн хоёр л хариултаас сонгон хариулна.

Дээрх асуулга нь хичээлийн агуулгын сонголт, багшийн хичээл зохион байгуулалт, үр чадвар зэрэг хичээлийн чанартай холбогдох олон талын асуултыг агуулсан байна. Мөн багшийн харилцааны соёл, ёс зүйн байдлыг үнэлэн гаргах асуултууд орсон байна. Гэвч эдгээр асуултад хангалттай, хангалтгүй гэсэн хоёрхон хариултаас сонгон хариулах нь багшид болон хичээлд үнэн зөв үнэлгээний дүн гаргахад маш учир дутагдалтай. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжсэн "Сургалтын хөтөлбөрийн бүтэцчилсэн хүрээ, боловсролын стандарт боловсруулах техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээ" төслийн багаас 2009 онд гаргасан тайланд, багшлах боловсон хүчин бэлтгэх ажлын чанар хангалтгүй байгааг тэмдэглээд, түүний шалтгааныг сургалтын агуулгаас илүү түүнийг зохион байгуулж буй арга барил, хандлага, харилцаа, соёл дутагдаж байгаатай холбон үзжээ¹. Багшлах боловсон хүчин бэлтгэх гол бааз болох МУБИС дээрх асуултуудаар багшийн хандлага, ёс зүй, харилцааг сайжруулах зорилготойгоор үнэлгээ аван, цааш сайжруулах асуудалд тусгах нь сургалтын чанарыг дээшлүүлэхэд хувь нэмэртэй болно.

Ч. Байгалмаа (2012) 2009, 2010, 2011 онд дээрх асуултуудаар багш, оюутнуудаас үнэлгээ аван, гарсан үр дүнд анализ хийж, жил жилүүдийн хэлбэлзлийг судалсан байна.

Олон улсын их сургуулиудтай харьцуулан судалсан нь

БНСУ, АНУ, Япон улсын их сургуулиудын хичээлийн үнэлгээний талаар судалж, МУБИС-ийн үнэлгээний сэтгэл ханамжийн судалгаатай харьцуулан үзлээ. Тухайн сургуулийн онцлогийг мөн харуулахын тулд асуулт хасалгүйгээр, мөн асуултыг дугаарласан байдал зэргийг аль болох байгаагаар нь харууллаа.

БНСУ-ын KAIST их сургууль

БНСУ-ын топ их сургууль KAIST-д улирлын эцэст оюутан судалсан бүх хичээлдээ үнэлгээ хийдэг тогтолцоотой. Хичээлийн үнэлгээг хийхээс нааш оюутан сургуулийн цахим системээс тухайн хичээлийн улирлын дүнгээ харах боломжгүй.

KAIST их сургуулийн дийлэнх хичээл нь англи хэл дээр заагддаг тул 5-р асуулт байна. Шинжлэх ухаан, технологийн сургууль учраас лекц, лаборатори голлосон тул түүндээ тохируулан асуулгыг нь лекц хичээл, лекц лаборатори хосолсон хичээл, лаборатори хичээл гэсэн төрлүүдээр авдаг.

¹ Багшлах сонирхолтой, авьяастай хүүхдийг оношлох, сонгон шалгаруулах шинжлэх ухааны үндэслэл боловсруулах нь" суурь судалгааны төслийн баримт бичиг, МУБИС, 2013.

Доор лекц хичээлийн үнэлгээний асуултуудыг танилцууллаа. Хичээлийн төрлүүдэд тохируулан асуултыг бага зэрэг өөрчлөн авдаг. Жишээ нь 3-р асуултын хувьд лаборатори хичээлийн үнэлгээнд "Оюутнуудад лаборатори, туршилтын хэрэгслийг хэрэглэх боломж хангалттай байсан уу?" гэж хичээлийн хэлбэрт тохируулан асуултыг тавьдаг байна.

АСУУЛТ

1. Бүтэц (Structure)
Хичээл бүхэлдээ системтэйгээр явагдсан уу?
Огт үгүй (0-20%), Үгүй (20-40%), Аль нь ч биш (40-60%), Тийм (60-80%), Үнэхээр тийм (80-100%)
2. Ойлгосон түвшин (Level of understanding)
Хичээлээр заасан зүйлийг ойлгосон уу?
Хэрэгтэй байсан уу?
Огт үгүй (0-20%), Үгүй (20-40%), Аль нь ч биш (40-60%), Тийм (60-80%), Үнэхээр тийм (80-100%)
3. Уур амьсгал (Atmosphere)
Хичээлийн үеэр оюутан чөлөөтэй оролцох (асуулт асуух, хэлэлцэх гэх мэт) боломжтой байсан уу? Оюутнуудын анхаарлыг татаж, бүтээлчээр сэтгэхийг дэмжиж байсан уу?
Огт үгүй (0-20%), Үгүй (20-40%), Аль нь ч биш (40-60%), Тийм (60-80%), Үнэхээр тийм (80-100%)
4. Хүртээмж (Level of contribution)
Энэ хичээлээр суралцаж буй хүрээнийхээ мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлж чадах уу?
Огт үгүй (0-20%), Үгүй (20-40%), Аль нь ч биш (40-60%), Тийм (60-80%), Үнэхээр тийм (80-100%)
5. Англи хэл (English)
Багш англи хэлээр ярьж, лекцийн материалаа англи хэлээр бэлтгэсэн байсан уу?
Үгүй, Тийм
6. Лекцийн бэлтгэл (Lecture preparation)
Хичээлийн бэлтгэлийг хангахад долоо хоногт хэдэн цаг зарцуулж байсан бэ?
1 цагаас бага, 1-3 цаг, 3-5 цаг, 5-7 цаг, 7 цагаас дээш
7. Дадлага ажил (Practice session)
Дадлага ажил хийгдсэн бол, хичээлээр зааж байгаа зүйлийг илүү сайн ойлгоход тус болсон уу?
Огт үгүй (0-20%), Үгүй (20-40%), Аль нь ч биш (40-60%), Тийм (60-80%), Үнэхээр тийм (80-100%)
8. Туслах багш (Assistant)
Хичээлд туслах багш байсан бол түүний ажилд та сэтгэл хангалуун байна уу?
Огт үгүй (0-20%), Үгүй (20-40%), Аль нь ч биш (40-60%), Тийм (60-80%), Үнэхээр тийм (80-100%)
9. Дүгнэлт (Overall)
Хичээлийн тухай ерөнхийд нь санал байвал



бичнэ үү. (өмнөх хичээлийн залгамж холбоо, гэрийн даалгаврын эргэх холбоо, туслах багшийн үүрэг гэх мэт)

Хичээлийн үнэлгээг 1-4 дүгээр асуултын хариултыг үндэслэн гаргадаг байна. 5-р асуултад нийт оюутны 80% нь тийм гэж хариулсан бол тухайн хичээлийг англи хэл дээр заажээ гэж дүгнэдэг. 6-р асуултад 7 цагаас дээш хугацааг оюутан хичээлийн бэлтгэлд зарцуулдаг гэсэн дүн гарвал тухай хичээлийн багшид сургуулийн зүгээс хичээлийн ачааллыг багасгахыг хүсдэг.

АНУ-ын Станфордын их сургууль

АНУ-ын их, дээд сургуульд мөн адил оюутан улирлын эцэст хичээлийн үнэлгээг заавал хийх ёстой. Дийлэнх их сургууль үнэлгээгээ онлайн хэлбэрээр авдаг. Станфордын их сургуулийн хичээлийн онлайн үнэлгээний асуултуудыг тус сургуулийн цахим хаягаас авлаа. Үнэлгээ хийх хугацааг оюутнуудад хоёр долоо хоног өгч, энэхүү хугацаа дууссанаас гурав хоногийн дараа оюутнууд хичээлд авсан улирлын дүнгээ сургуулийн цахим системээс харах боломжтой болдог.

ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ (form)

Ерөнхий мэдээлэл/сонгох/

- Хэддүгээр курс
- Суралцаж буй салбар
- Хичээлийн төрөл
- Энэ хичээлийг сонгосон шалтгаан
- Хичээлд суусан байдал
- Ямар дүн авна гэж хүлээж байна?
- Хичээлийн цагаас гадуур энэ хичээлд

зориулсан хугацаа

- Үнэ цэнтэй байсан хувь
- Хичээлийн агуулгын чанар

Доорх асуултуудад онц, маш сайн, сайн, боломжийн, муу, үнэлэх боломжгүй(Excellent, Very good, Good, Fair, Poor, N/A) гэсэн 6 хариултаас сонгож хариулна.

Ерөнхий үнэлгээ

- Багшийн ерөнхий заах арга зүй
- Хичээлийн зорилтыг ойлгомжтой томъёолсон ба оюутнуудад мэдэгдсэн

Багшийн зохион байгуулалт ба ойлгомжтой байдал

- Хичээлд ашигласан материал нь бүхэл системтэй мэдлэгийг агуулсан
- Агуулгыг ойлгомжтой тайлбарсан
- Хичээлийн материалыг тохиромжтой хурдаар/хэмнэлээр ашигласан

Багшийн оюутныг хичээлд оролцуулж, сорьж буй чадвар

- Ойлголт, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхэд ач холбогдол өгсөн
- Хичээлийн сэдвүүд хоорондоо холбогдож байсан

Багшийн оюутантай харилцах харилцаа

- Оюутнууд суралцаж байгаа эсэхийг бодолцож байсан

- Оюутны сонирхлыг татаж, идэвхжүүлж байсан
- Хичээлээс гадуур зөвлөлдөх боломжтой байсан

Хичээлийн бүтэц, агуулга, үнэлгээ

- Хичээлийн агуулга үнэ цэнтэй, хэрэгтэй байсан

- Хичээлийн сэдвүүд уялдаа холбоо, дэс дараа сайтай бүтэцчилэгдсэн

- Оюутныг хэрхэн үнэлэх тухай тодорхой тайлбарласан

- Дүнг шударга байхаар зохиосон, хэрэгжүүлсэн

Лаборатори хэрэглэсэн бол

- Лабораторийг хичээлд үр дүнтэйгээр шигтгэсэн

Нээлттэй хариулж бичих асуултууд

Багшийн заах арга зүй, харилцааны тухай

- Сайн тал
- Сайжруулах зөвлөгөө

Хэрэглэсэн сурах бичгийн талаар сайн тал, дутагдалтай талыг бичих. Аль сурах бичиг, унших материал хамгийн хэрэгтэй, эсвэл хэрэггүй байсан бэ? Яагаад?

- Сайн тал
- Дутагдалтай тал

Бие даалт болон шалгалтын талаар. Хүндийн түвшин, хэмжээ, хэр тогтмол, хэрэгцээтэй байдал, эргэн санахаас илүү ойлголтыг шалгаж байсан эсэх.

- Сайн тал
- Сайжруулах зөвлөгөө

Хичээлийн талаар ерөнхийд нь бичих зүйл байвал бичнэ үү.

- Сайн тал
- Сайжруулах зөвлөгөө

Японы Токиогийн их сургууль, Ерөнхий эрдмийн факультет

Токиогийн их сургуульд бүх оюутан 1, 2-р курстээ ерөнхий эрдмийн факультетэд харьяалагдан, 3-р курсээсээ мэргэжил тус бүрээрээ факультетэд хуваарилагддаг. Ерөнхий эрдмийн факультетэд суралцаж байх үед оюутан судалсан бүх хичээлийн сүүлчийн хичээл дээр доорх асуултын дагуу үнэлгээ хийх ёстой. Харин дээр танилцуулсан жишээнээс ялгаатай нь оюутан сүүлийн хичээл дээрээ суугаагүйгээс үнэлгээний хуудсыг бөглөөгүй байсан ч оюутан дүнгээ харах боломжтой.

ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АНКЕТ

2013 оны зуны улирал

1. Хичээлийн 4 оронтой код
2. Юуны анги
3. Элссэн он
4. Энэ хичээлд хэр суусан бэ?
5. Энэ хичээлд бэлдэж идэвхтэй бэлдэж, уншиж байсан бэ?
6. Энэ хичээлийн агуулга хэр сонирхолтой

байсан бэ?

Багшийн хичээл хэрхэн явуулж байсан талаар

7. Багшийн ярианы байдал хэр ойлгомжтой байсан бэ?

8. Самбар, проекторын үг үсэг ойлгомжтой байсан уу?

9. Хичээлийн агуулгын хэмжээний тухай?

10. Бүхэлд нь аваад үзэхэд хичээлийн цаг ашиглалт зохимжтой байсан уу?

11. Хичээл бүхэлдээ бэлтгэл сайн, сайн төлөвлөгдсөн байсан уу?

12. Багшийн тайлбарлах байдал ойлгомжтой байсан уу?

13. Оюутны асуултад багшийн хариулт ойлгомжтой байсан уу?

Хичээлийн агуулгын талаар таны үнэлгээ

14. Таныхаар энэ хичээлийн агуулгын хүндийн түвшин хэр байсан бэ?

15. Энэ хичээлээр шинэ мэдлэг, чадвар хэр олж авсан бэ?

16. Энэ хичээлийн агуулгын талаар хэр үнэлж байна вэ?

Энэ хичээлийн талаар санал байвал чөлөөтэй бичнэ үү. Хичээлийн аргагүй, хэрэглэсэн материал, хэрэглэгдэхүүний талаар сайжруулах тухай санал бодол байвал.

Мөн хичээлийн хэлбэрээр буюу лекцийн хичээлийн, семинар дадлагын хичээлийн үнэлгээ гэж бага зэрэг асуултын тавилыг өөрчилж авдаг байна.

Япон улсын их, дээд сургуулиуд

Хичээлийн үнэлгээг ямар ямар асуултаар хийдэг тухай Японы их, дээд сургуулиудын оюутнуудаас авдаг хичээлийн үнэлгээний талаар дараах ерөнхий судалгааны дүн байна. Тоон мэдээлэл нь их, дээд, 2-жилийн богино хугацааны дээд сургуулиудыг хамран авахад асуулт тус бүрээр үнэлгээний асуултад оруулсан их, дээд сургуулийн тоо болно.



NAGAHARA Kazuo нар (2012) ("Их сургуулийн боловсролын агуулгын шинэчлэлийн байдал, 2010" Боловсролын яам)

Токио Гакүгэй их сургууль

Японы Токио Гакүгэй багш бэлтгэх их сургуулийн хичээлийн үнэлгээний асуултууд дээр жишээ болгон авсан сургуулиудын ашигладаг асуултуудаас өөр, өвөрмөц онцлогтой байгаа тул энд танилцууллаа. Тухайн сургуулийн өөрийн боловсролын зорилго буюу оюутнуудын хичээлээр эзэмших ёстой чадварт сургах хичээл байсан эсэх талаар асуулт байгаа нь дээрх бүх сургуулиас ялгарч байна.

ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АНКЕТ

Боловсролын зорилготой холбогдох асуултууд

1. Хамтран хийх, ажиглалт хийн хэрэгжүүлэх чадварт сургах хичээл байсан
2. Сургуулийн хөгжил, хичээлийн хөгжлийн тухай бүтээлчээр оролцох чадварт сургах хичээл байсан
3. Практик болон онолыг хослуулсан хичээл байсан
4. ЕБС-ийн сургалтад учирч буй асуудлыг шийдвэрлэх чадварт сургах хичээл байсан



Агуулга, аргазүйн холбогдох асуултууд

1. Хичээлийн зорилт тодорхой байсан
2. Хичээлийн агуулга үр өгөөжтэй байсан
3. Хичээлийн арга зүйд санаачилгатай

хандсан байсан

4. Хичээлээс урам авах зүйл их байсан
- Багштай холбогдох асуулт

1. Багш ойлгомжтой тайлбарладаг
2. Багшаас идэвх, санаачилга мэдрэгдэж

байсан

Хичээлд оролцсон байдал

1. Хичээлд идэвхтэй оролцсон
2. Ерөнхийдөө энэ хичээлийг судалсандаа

сэтгэл хангалуун байна

Хариултын сонголтууд бүх асуултын хувьд адил дараах 5 сонголттой:

- 5:тийм, 4:ерөнхийдөө тийм, 3:аль нь ч биш, 2:бараг үгүй, 1:үгүй.

ДУГНЭЛТ

Олон улсын жишээнүүдэд нийтлэг ажиглагдаж байгаа зүйл бол үнэлгээний асуултууд нь хичээлийн чанар, үр дүнд анализ хийж болохуйц тавигдсан байна. Хичээлийн агуулгын түвшин, арга барил, явцаас гадна багшийн хандлага, идэвх санаачилга, уур амьсгал бүрдүүлэлт зэрэг тухайн хичээлийн чанартай шууд холбогдох баримтуудтай холбогдож байна. Мөн оюутны хичээлд суусан байдлыг асуусан нь тухай оюутны хичээлд өгсөн үнэлгээ хэр бодитой байх тухай мэдээлэл болж байна.

Хичээлийн үнэлгээг үр дүнтэй хийснээр хичээл тус бүрийн үнэлгээнээс гадна тухайн хөтөлбөрийн үнэлгээ, нийт сургалтын бүтцийн үнэлгээ, цаашлаад тэнхим, сургуулийн хөгжлийн байдалд ач холбогдолтой.

Хичээлийн үнэлгээний дээрх олон улсын жишээнүүдээс АНУ-ын Станфордын их сургуулийн асуултууд хичээл, багшийн талаар бүхий л хүрээг хамарсан байгаа тул үндсэн загвар болгоод зарим асуултыг нэмж, хасан, манай улсад хэрэглэж болохуйц шинэ асуулгын хувилбарын санаа боловсруулж үзлээ.

АСУУЛГЫН ХУВИЛБАР

Оюутны ерөнхий мэдээлэл /тодорхой хувь, мужаас сонгон хариулах/

- Хичээлд суусан байдал /1 ч таслаагүй, 1-2 удаа тасалсан, 3-5 удаа тасалсан, 6-8 удаа, 9-өөс дээш/

- Хичээлийн цагаас гадуур энэ хичээлд зориулсан хугацаа /1 цагаас бага, 1-2 цаг, 2-3 цаг, 3-5 цаг, 5 цагаас дээш/

/Доорх асуултууд дор бүрээ тийм, ерөнхийдөө тийм, дундаж, бараг үгүй, үгүй гэсэн 5 шатны сонголттой байна. /

Багшийн арга зүй, зохион байгуулалт

- Хичээлд ашигласан материал нь бүхэл, системтэй мэдлэгийг агуулсан

- Агуулгыг ойлгомжтой тайлбарласан
- Багш арга зүйдээ санаачилгатай хандсан
- Самбар, powerpoint-ын хэрэглээ зэрэг нь тохиромжтой байсан

Багшийн оюутантай харилцах харилцаа

- Оюутанд асуулт асуух, санал бодлоо илэрхийлэх боломжийг олгож байсан

- Оюутнууд суралцаж байгаа эсэхийг бодолцож байсан

- Хичээлээс гадуур зөвлөгөө авах боломжтой байсан

Хичээлийн бүтэц, агуулга, үнэлгээ

- Хичээлийн агуулга үнэ цэнтэй, хэрэгтэй байсан

- Хичээлийн сэдвүүд уялдаа холбоо, дэс дараа сайтай бүтэцчилэгдсэн

- Оюутныг хэрхэн үнэлэх тухай тодорхой тайлбарласан

- Бие даалт хүндийн түвшин, хэмжээ тохирсон байсан

Энэ хичээлийг ерөнхийд нь авч үзэхэд сэтгэл хангалуун байна уу?

/Нээлттэй хариулж бичих асуултууд/

Багшийн заах арга зүй, харилцааны талаар саналаа чөлөөтэй бичнэ үү.

- Сайн тал:
- Сайжруулах зөвлөгөө:

Хичээлийн талаар ерөнхийд нь бичих зүйл байвал бичнэ үү.

- Сайн тал:
- Сайжруулах зөвлөгөө:

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Байгалмаа, Ч. (2012). МУБИС-ийн багш нарын үйл ажиллагааны талаарх оюутны үнэлгээнд хийсэн анализ. *Оюуны хөтөч*, 7

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль. (2014. 04). Curriculum Guide-Course Evaluation. *Их дээд сургуулийн сургалтын үйл ажиллагааг чанаржуулах асуудалд*. Улаанбаатар

Японы Токиогийн их сургуулийн цахим хуудас http://lecture.ecc.u-tokyo.ac.jp/~yamaguch/prog-cons/2013/Questionnaire_01.pdf

АНУ-ын Станфордын их сургуулийн цахим хуудас <https://studentaffairs.stanford.edu/registrar/students/evals-downloads>

NAGAHARA Kazuo et al. *A Questionnaire Survey of Course Evaluation Conducted in Japanese Universities*, Journal of Hokkaido Bunkyo University (12), 157-172, 2011-03-25 (in Japanese).